**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Булган сумын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/93/НА-СА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг<br><br>2022 он | Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: **7034-2580**<br>Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Ж.**Энхцоодол**<br>Утас: **7034-2716**<br>Цахим хаяг: : enkhtsoodolj@**audit.gov.mn**<br>ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.**Цэрэннадмид**<br>Утас: **9511-2689**<br>Цахим хаяг: tsesb.audit@**gmail.com**<br>**Аудитор Ш.Ганчимэг**<br>**Утас: 99377360**<br>**Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com** |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт....................................................................................................3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ...............................................................5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....................................................................................................13
 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..............................................................................................13
 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.............................................................................................13
 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..................................................................................13-14
 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..............................14-16
4. Аудитын тайлан.......................................................................................................................................17
 4.1 Ерөнхий зүйл ...................................................................................................................................17
 4.2 Материаллаг байдал ........................................................................................................................17
 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт...........................................................................................17
 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...........................17-18
 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........................................................19
 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........................................................................................19
5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................................19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..............................................................................21


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СӨБ | Цэцэрлэгийн өмнөх боловсрол |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 132

танай______________ны №_______________т

БУЛГАН СУМЫН
ГУРАВДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.ГЭРЭЛТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Булган сумын 3 дугаар сургуулийн 2022 оны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс 990,503.7 мянга, орон нутгийн тусвөөс төсвөөс 330,347.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 96.0 хувьтай хэрэгжжээ.

Тайлант онд БШУС-ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар хуваарилсан 55,445.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардлаар төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, тоног төхөөрөмж худалдан авч хөрөнгийг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

D:/bichighereg/2023A4toot

006020153

**Аудитын гол асуудал**

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад  үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын даргын 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 8 зорилтын хүрээнд 71 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 97.0 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Үлдэгдэл | Үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **76,876,097.09** | **113,720,128.09** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | **52,812,326.00** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 52,812,326.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 52,812,326.00 |
| **33** | **АВЛАГА** | **20,939,800.00** | - |
| **335** | **Бусад авлага** | 20,939,800.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 20,939,800.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **55,936,297.09** | **60,907,802.09** |
| **351** | **Түүхий эд материал** | 49,970.00 | 4,392,050.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 49,970.00 | 4,392,050.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | 1,642,700.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **55,886,327.09** | **54,873,052.09** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,341,200.00 | 660,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,382,502.09 | 44,575,902.09 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,139,360.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 2,736,265.00 | 3,070,850.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,287,000.00 | 6,565,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,236,917,339.59** | **4,270,414,786.03** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,236,917,339.59 | 4,270,414,786.03 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,112,888,506.11 | 4,146,588,952.53 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,186,400,000.00 | 4,186,400,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (250,021,110.92) | (284,907,777.56) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 147,208,602.02 | 234,559,527.02 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (63,300,123.36) | (79,462,918.48) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 115,008,096.00 | 115,008,096.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (35,510,447.86) | (41,595,746.68) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | - | 125,500.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,565,760.00 | 10,565,760.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,698,016.00) | (4,226,304.00) |
| 39217 | Ном | 6,235,746.23 | 10,122,816.23 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 124,028,833.48 | 123,825,833.50 |
| 39301 | Програм хангамж | 2,030,000.00 | 2,030,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (701,166.52) | (904,166.50) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,313,793,436.68** | **4,384,134,914.12** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **3,521,100.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 3,521,100.00 |
| **413** | **Өглөг** | - | 3,521,100.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 3,521,100.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,375,200.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 2,145,900.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,313,793,436.68** | **4,380,613,814.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,313,793,436.68 | 4,380,613,814.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,191,093,436.68 | 4,257,913,814.12 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,191,093,436.68 | 4,191,093,436.68 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 66,820,377.44 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,313,793,436.68** | **4,384,134,914.12** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,417,250,882.61** | **1,333,876,895.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **57,693,975.61** | **13,025,695.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,139,175.61 | 13,025,695.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,139,175.61 | 13,025,695.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,139,175.61 | 13,025,695.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 54,554,800.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 54,554,800.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,359,556,907.00** | **1,320,851,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,167,606,800.00 | 990,503,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 751,704,100.00 | 990,503,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 415,902,700.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 816,707.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 816,707.00 | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 191,133,400.00 | 330,347,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 191,133,400.00 | 330,347,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,009,010,384.60** | **1,267,056,517.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,009,010,384.60** | **1,267,056,517.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **988,352,943.43** | **1,229,195,144.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **599,727,750.83** | **721,507,621.48** |
| 210101 | Үндсэн цалин | 470,742,999.01 | 534,252,021.94 |
| 210102 | Нэмэгдэл | 80,275,349.44 | 154,362,768.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,353,962.00 | - |
| 210104 | Урамшуулал | 29,355,440.38 | 32,892,830.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **76,321,000.00** | **86,343,178.46** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,294,910.49 | 58,713,361.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,006,522.37 | 6,907,454.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,805,217.90 | 5,525,963.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,201,304.47 | 1,381,490.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,013,044.77 | 13,814,908.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **189,633,400.00** | **282,831,001.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,192,968.51 | 16,196,701.00 |
| 210302 | Түлш, халаалт | 177,624,431.49 | 247,448,608.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 816,000.00 | 19,185,692.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,529,900.00** | **1,822,860.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 650,500.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 765,000.00 | 1,139,360.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,544,840.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 18,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,891,600.00 | 55,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,467,160.00 | 628,500.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,192,800.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **19,025,640.00** | **34,739,395.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 183,700.00 | 48,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,689,060.00 | 34,451,095.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 152,880.00 | 240,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,483,000.00** | **3,547,670.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,483,000.00 | 3,547,670.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 123,500.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 123,500.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **100,000.00** | **5,284,020.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 100,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 5,284,020.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 88,408,752.60 | 93,119,398.56 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,703,500.00 | 20,070,650.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,724,000.00 | 15,182,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 84,981,252.60 | 57,866,048.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,657,441.17** | **37,861,373.06** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **17,366,590.00** | **37,861,130.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,316,590.00 | 37,861,130.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,050,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,290,851.17 | 243.06 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,290,851.17 | 243.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **408,240,498.01** | **66,820,377.44** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **408,240,498.01** | **66,820,377.44** |

*Булган аймаг дахь Төрийн аудитын газар*

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,414,111,707.00** | **1,320,851,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **54,554,800.00** | **-** |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 54,554,800.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 54,554,800.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,359,556,907.00** | **1,320,851,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,167,606,800.00 | 990,503,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 751,704,100.00 | 990,503,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 415,902,700.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 816,707.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 816,707.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 191,133,400.00 | 330,347,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 191,133,400.00 | 330,347,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **940,371,307.00** | **1,210,068,874.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **940,371,307.00** | **1,210,068,874.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **921,779,065.83** | **1,167,125,680.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 595,727,750.83 | 719,950,928.76 |
| 210101 | Үндсэн цалин | 373,691,467.30 | 536,734,787.92 |
| 210102 | Нэмэгдэл | 151,134,142.15 | 150,323,310.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,911,462.00 | - |
| 210104 | Урамшуулал | 41,990,679.38 | 32,892,830.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,321,000.00 | 87,899,871.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,385,900.00 | 61,859,015.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,891,700.00 | 6,385,610.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,879,100.00 | 5,108,248.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,196,700.00 | 1,158,227.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,967,600.00 | 13,388,768.35 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 189,633,400.00 | 282,831,001.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,192,968.51 | 16,196,701.00 |
| 210302 | Түлш, халаалт | 166,793,450.00 | 247,448,608.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,646,981.49 | 19,185,692.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,325,407.00 | 457,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 720,107.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,544,840.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 18,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,495,560.00 | 457,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,546,900.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 19,724,315.00 | 34,021,390.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 183,800.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 19,307,635.00 | 34,021,390.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 232,880.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,500,000.00 | 4,459,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 4,459,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 123,500.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 123,500.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 155,000.00 | 6,966,720.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 155,000.00 | 1,642,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 5,324,020.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,268,693.00 | 30,538,470.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,818,200.00 | 19,669,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,450,493.00 | 10,869,170.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,592,241.17** | **42,943,193.06** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,301,390.00 | 42,942,950.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,251,390.00 | 42,942,950.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,050,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,290,851.17 | 243.06 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,290,851.17 | 243.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **473,740,400.00** | **110,782,326.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,282,900.00** | **57,970,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,282,900.00** | **57,970,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,282,900.00 | 57,970,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 3,282,900.00 | 57,970,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,282,900.00)** | **(57,970,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 470,457,500.00 | **52,812,326.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **52,812,326.00** |

*Булган аймаг дахь Төрийн аудитын газар*

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 122,700,000.00 | 4,252,117,638.67 | 4,374,817,638.67 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **122,700,000.00** | **4,252,117,638.67** | 4,374,817,638.67 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | (61,024,201.99) | (61,024,201.99) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **122,700,000.00** | **4,191,093,436.68** | 4,313,793,436.68 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **122,700,000.00** | **4,191,093,436.68** | 4,313,793,436.68 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **122,700,000.00** | **4,191,093,436.68** | 4,313,793,436.68 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | 66,820,377.44 | 66,820,377.44 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **122,700,000.00** | **4,257,913,814.12** | 4,380,613,814.12 |

*Булган аймаг дахь Төрийн аудитын газар*

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,320,851,200.00** | **1,268,038,630.94** | **52,812,569.06** | **96.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,320,851,200.00 | 1,210,068,630.94 | 110,782,569.06 | 91.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,277,905,800.00 | 1,167,125,680.94 | 110,780,119.06 | 91.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **765,086,000.00** | **719,950,928.76** | **45,135,071.24** | **94.1** |
| 210101 | Үндсэн цалин | 568,221,200.00 | 536,734,787.92 | 31,486,412.08 | 94.5 |
| 210102 | Нэмэгдэл | 177,661,700.00 | 150,323,310.14 | 27,338,389.86 | 84.6 |
| 210104 | Урамшуулал | 19,203,100.00 | 32,892,830.70 | (13,689,730.70) | 171.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **95,476,100.00** | **87,899,871.18** | **7,576,228.82** | **92.1** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,996,600.00 | 61,859,015.73 | 3,137,584.27 | 95.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,646,600.00 | 6,385,610.88 | 1,260,989.12 | 83.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,117,300.00 | 5,108,248.30 | 1,009,051.70 | 83.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,519,600.00 | 1,158,227.92 | 361,372.08 | 76.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,196,000.00 | 13,388,768.35 | 1,807,231.65 | 88.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **282,831,100.00** | **282,831,001.00** | **99.00** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,196,800.00 | 16,196,701.00 | 99.00 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 247,448,600.00 | 247,448,608.00 | (8.00) | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,185,700.00 | 19,185,692.00 | 8.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **457,400.00** | **457,400.00** | **-** | **100.0** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 457,400.00 | 457,400.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **34,026,600.00** | **34,021,390.00** | **5,210.00** | **100.0** |
| 210502 | Хоол, хүнс | 34,026,600.00 | 34,021,390.00 | 5,210.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,459,900.00** | **4,459,900.00** | **-** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 4,459,900.00 | 4,459,900.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,175,200.00** | **6,966,720.00** | **2,208,480.00** | **75.9** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,642,700.00 | 1,642,700.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,532,500.00 | 5,324,020.00 | 2,208,480.00 | 70.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **86,393,500.00** | **30,538,470.00** | **55,855,030.00** | **35.3** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,094,800.00 | 19,669,300.00 | 55,425,500.00 | 26.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,298,700.00 | 10,869,170.00 | 429,530.00 | 96.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,945,400.00** | **42,942,950.00** | **2,450.00** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **42,945,400.00** | **42,942,950.00** | **2,450.00** | **100.0** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 42,945,400.00 | 42,942,950.00 | 2,450.00 | 100.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **57,970,000.00** | (57,970,000.00) | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 57,970,000.00 | (57,970,000.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,320,851,200.00** | **1,320,851,200.00** | **-** | **100.0** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **990,503,700.00** | **990,503,700.00** | **-** | **100.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 990,503,700.00 | 990,503,700.00 | - | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **330,347,500.00** | **330,347,500.00** | **-** | **100.0** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 330,347,500.00 | 330,347,500.00 | - | 100.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **52,812,326.00** | (52,812,326.00) | |

*Булган аймаг дахь Төрийн аудитын газар*

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Булган сумын 3 дугаар сургууль нь  сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Хүүхдийн нийгэм, сэтгэлзүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, сурах тэгш боломжийг бүрдүүлэхэд хамтран суралцах арга барилыг эзэмшихэд сургалт, үйл ажиллагаагаа чиглүүлж  гүйцэтгэлийн үр дүн,чанарыг дээшлүүлнэ” гэсэн  зорилт дэвшүүлэн ажиллажээ.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 1/1649 дугаар албан бичгээр ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Булган сумын 3 дугаар сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70,341.5 мянган төгрөгөөр буюу 1.63 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 52,812.3 | 52,812.3 |
| Авлага | - | - | - |
| Байгууллагаас авах авлага | 20,939.8 | - | (20,939.8) |
| Бараа материал | 55,936.3 | 60,907.8 | 4,971.5 |
| Үндсэн хөрөнгө | 4,236,917.3 | 4,270,414.8 | 33,497.5 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | | (57.866.0) | |
| **Нийт хөрөнгө** | **4,313,793.4** | **4,384,134.9** | **70,341.5** |
| Өр төлбөр | | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,313,793.4 | 4,380,613.8 | 66,820.4 |
| Өр төлбөр /богино хугацаат/ | | 3,521.0 | 3,521.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,313,793.4** | **4,384,134.9** | **70,341.5** |

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансанд улсын төсвийн 52,812.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Тайлант онд өмнөх оны 20,939.8 мянган төгрөгийн авлагад харилцагч байгууллагаас 13,000.0 мянган төгрөгийн ухаалаг самбар, 7,939.8 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжүүдийг авч, бүрэн барагдуулсан байна.

Төсвийн хөрөнгөөр 112,443.4 мянга, хандив тусламжаар 572.0 мянган төгрөгийн мянган төгрөгийн бараа материал худалдан авч, тайлант хугацаанд 108,043.8 мянган төгрөгийн материалыг зарцуулан, 60,907,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,270,414.8 мянган төгрөг болж 33,497.5 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 32,417.5 мянган төгрөгийн ухаалаг самбар тоног төхөөрөмж сургалтын хэрэглэгдэхүүн, 55,445.0 мянган төгрөгийн таблет, ухаалаг дэлгэц, 2,525.0 мянган төгрөгийн бусад тоног төхөөрөмж худалдан авч хандив тусламжаар 976.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч тайлант хугацаанд 57,886.0 элэгдэл байгуулсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,380,613.8 мянган төгрөг болж 66,820.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 83,374.0 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурахад тусламж санхүүжилтийн орлого 93,260.5 мянган төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 9,886.5 төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 258,046,1 мянган төгрөгөөр өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 131,802.0 мянга, тогтмол зардал 93,197.6 мянга, хоол хүнс 15,713.8, тэтгэмж урамшууллын зардал 21,544.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

**Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,361,690.5 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид

хүргүүлснийг 1,155,391.2 мянган төгрөгөөр баталж, 206,299.3 төгрөгөөр бууруулсан байна. Тайлант онд дээрх төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж, оны эцэст 1,320,815.2 мянган төгрөгөөр тодотгон баталжээ.

Мөн 2022 онд боловсролын салбарын төсвийн шинэчлэл хийгдсэнээр хангамж бараа материал, нормативт зардал, шуудан холбоо, интернетийн төлбөр, нормын хувцас, албан томилолт, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс зэрэг зардлууд хасагдсан, нэг хүүхдийн хувьсах зардлын хэмжээ өөрчлөгдсөн зэрэг олон шалтгаан нь төсвийн төлөвлөлт болон батлагдсан төсвийн зөрүүнд нөлөөлсөн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 706,668.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 111,166.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 817,834.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 14,910.8 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 794,302.2 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11,273.4 мянга, цалин 3,039.0 мянга, нормативт зардал /хоол/, 10,121.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| Хөтөлбөр | д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| **71802 Ерөнхий боловсрол** | 1 | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ | 3,013.0 | 3,916.7 | (903.7) | 130.0 |
| | 2 | 80312- Сургалт семинар | 1,506.5 | 2,071.5 | (565.0) | 137.7 |
| | 3 | 81605- Эрүүл мэндийг дэмжих | 3,464.9 | 3,464.9 | - | 100 |
| | 4 | 81801- Үдийн цай хөтөлбөр | 42,945.4 | 53,979.5 | (11,033.6) | 125.7 |
| | 5 | 81806-Дотуур байрны хүүхдийн хоол | 50,111.7 | 44,507 | 5,604.7 | 89.06 |
| | 6 | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 55,445.0 | 110,890 | (55,445.0) | 200.0 |
| | 7 | 81823- Боловсролын багшийн сургалт | 6,779.2 | 8,424.8 | 1,645.6 | 124.2 |
| | 8 | 81834- Боловсролын стандарт сургалт | 728,168.5 | 719,802.6 | 149,795.8 | 98.9 |
| | 9 | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 97,426.8 | 58,636.7 | 3,074.2 | 60.2 |
| | 10 | 81848-Сурах бичгийн түрээс | 1,642.7 | 1,642.7 | - | 100.0 |
| | 12 | 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 287,291 | 287,291 | - | 100.0 |
| | 13 | 80112- Нийтлэг үйлчилгээ | 43,056.5 | 43,056.4 | - | 100.0 |
| **Нийт** | | | **1,320,851.2** | **1,337,683.8** | **298,513.7** | **101.3** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Булган сумын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Төрийн хэмнэлтийн тухай

хуулийн хэрэгжилт болон багш нарын эрүүл мэндийн нэмэлт үзлэг оношлогоотой холбоотой асуудлаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Гантуяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

3 дугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,320,851.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,208.5 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Энэ хуулийн хүрээнд батлагдсан төсөв 52,812.3 мянган төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн нь урсгал зардал 110,782.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн ч хөрөнгө худалдан авахад 57,970.0 мянган төгрөг зарцуулсан нь нөлөөлсөн. Тайлант онд үндсэн цалин 45,135.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 55,425.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь батлагдсан төсөвтэй холбоотой байна.

Сургалт, туршлага солилцох, нөхөрсөг уулзалт тэмцээн зохион байгуулахад, бараа үйлчилгээний бусад зардлаас 3,372.5 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоолын 1.3-т “Байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 100.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 20,939.8 мянган төгрөгийн албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 100.0 | 1 | 100.0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 20,939.8 | 1 | 20,939.8 | 100 |
| Зөвлөмж | 3 | 0 | 1 | 0 | 100 |
| **Нийт дүн** | 1 | 21,039.8 | 1 | 21,039.8 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 6,677.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоотой холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u>

Багш, ажилтныг эрүүл мэндийн нэмэлт үзлэг оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулж, хамтран ажиллах тухай гэрээ байгуулсан ч уг гэрээнд үзлэг оношилгооны нэр

төрөл, төлбөр, хамрагдах хүний тоо тусгагдаагүй, гэрээг дүгнэлгүйгээр 3,304.9 мянган төгрөг төлсөн байна.

Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/238, А/340 дүгээр тушаалын 3.1, 3.2, БШУС-ын 2022 оны 07 дугаар сарын 22-ны А/259 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамруулах заавар”-ын 2.6.1, 2.6.5, 2.8.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Цаашид дээрх журам, зааврын дагуу эрүүл мэндийн үзлэг, оношилгоог зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:*

Сургалт, туршлага солилцох, нөхөрсөг уулзалт тэмцээн зохион байгуулахад, бараа үйлчилгээний бусад зардлаас 3,372.5 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Багш ажилтныг ерүүл мэндийн нэмэлт үзлэг оношилгоонд хамруулах ажлыг холбогдох журам, зааврын дагуу зохион байгуулаагүй | 1 | 3,304.9 | - | - | | | 1 | 3,304.9 | - | - | - | - |
| Дүн | 1 | 3,304.9 | | | | | 1 | 3,304.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Сургалт, туршлага солилцох, уулзалт тэмцээн зохион байгуулсан | 1 | 3,372.5 | | | | | 1 | 3,372.5 |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 3,372.5 | - | - | - | - | 1 | 3,372.5 |